



Оюу толгойн танилцуулга

2017 оны 3 дугаар сар

Оюу толгой тоон хэлээр



Үйл ажиллагаа 2013 оноос эхэлсэн

- 2016 онд 355 хоног гэмтэл, бэртэлгүй ажиллав. Гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт **0.22** байгаа нь Рио Тинто компанийн хэмжээнд хамгийн бага гэмтэл, бэртэл тохиолддог, аюулгүй ажиллагааг сайн хангадаг уурхайн нэг болж байна.
- 2016 онд **846,600** тонн баяжмал үйлдвэрлэж; энэ онд **130,000 – 160,000** тонн баяжмал дахь зэс, **100,000 – 140,000** унци баяжмал дахь алт үйлдвэрлэхээр төлөвлөж байна.
- 2013 оноос хойш экспортод ачуулсан баяжмалын хэмжээ **3 сая тонн** орчимд хүрээд байна.

Оюу толгой тоон хэлээр

- Нийт ажиллах хүчний 90-ээс дээш хувийг Монгол иргэд бүрдүүлж байгаа бөгөөд мэргэжлийн боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийж, олон улсад өрсөлдөхүйц чадварлаг мэргэжилтэн бэлтгэхийг чухалчилж байна
- Нийт ажиллагсдын тоо 9,306 ба түүнээс 6,727 нь гэрээт ажилчид байна
- Өмнөговь аймгаас 70 сая ам.долларын бараа үйлчилгээг худалдан авалт хийсэн
- 2016 онд 210.6 сая ам.долларыг татвар, хураамж болон бусад төлбөрт төлсөн
- 2010 оноос хойш Монголын компаниудтай хийсэн худалдан авалт, Монгол Улсын төсөвт байгууллагуудад төлж буй татвар, хураамж, ажилчдын цалин зэргээр улсын хэмжээнд 6.1 тэрбум гаруй ам.доллар зарцуулаад байна



Бүх тоо баримтууд 2016 оны эцсийн байдлаар.

Боловсрол, сургалт



Мэргэжлийн сургалт ба гэрээт суралцагчийн хөтөлбөр

- 2016 онд манайд нийт 228 гэрээт суралцагч, 17 шинэ төгсөгч, 54 дадлагажигч оюутан суралцаж ажилласан
- 170 гэрээт суралцагч төгсөж Австрали Стандартын Мэргэшлийн гэрчилгээгээ гардаж авсан
- 38 гэрээт суралцагч 2017 оны 6-р сар хүртэл үргэлжлүүлэн суралцах ба тэднийг төгссөний дараа 28 шинэ суралцагч элсүүлж авна

Үйл ажиллагаан дахь манлайллын хөгжүүлэлт

- Гүйцэтгэх удирдлагын багийн гуравны нэг нь Монголчууд
- Нийт менежерүүдийн 60% нь Монголчууд
- Ахлах мэргэжилтнүүдийн 75%, ахлах ажилтнуудын 99% нь Монголчууд
- Манлайллыг хөгжүүлэх сургалтууд үргэлжилж байна




- 2015 онд боловсрол сургалтын хөтөлбөрийн чиглэлд 3.2 сая ам.доллар зарцуулсан
- Дээд боловсролын салбарт хэрэгжүүлж буй оюутны тэтгэлэгт хөтөлбөрүүдээрээ уул уурхай болон холбогдох салбаруудад ажиллах өндөр мэдлэг, ур чадвартай мэргэжилтнүүдийг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж байна.
- 2010-2015 онуудад Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай сургалт, боловсролын чиглэлээр хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж Монгол Улсын ажиллах хүчийг хөгжүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог шинэчлэн сайжруулахад чиглэгдсэн хөтөлбөрүүдийг 126 сая ам.доллараар санхүүжүүлсэн юм.

Байгаль орчин

Усны зохистой хэрэглээ

(тонн хүдэр боловсруулахад зарцуулсан шоо метр ус-сараар)

Ижил төрлийн зэсийн уурхайнуудын олон
улсын дундаж үзүүлэлт



Ус дахин ашиглалт

(хувь-сараар)

Дахин ашиглалтын зорилт (80%)



2016 онд "Оюу толгой"-н баяжуулах үйлдвэрт нэг тонн хүдэр боловсруулахдаа дунджаар 0.423 шоо метр ус ашигласан. Зэсийн уурхайнуудын дэлхийн дундаж 1.2 шоо метр байдаг. Ус дахин ашиглалтын түвшин энэ хугацаанд 86.2 хувь байлаа.



- Кемпийн бохир усны дахин ашиглалт 100 хувьтай, байгаль орчинд хаягдал үүсгэдэггүй
- Хаягдлын далан дахь усны 10 хувийг дахин ашиглах боломж бүрдүүлэн ууршилтыг бууруулсан
- Дэвшилтэт өтгөрүүлэгч ашиглан хэрэглэгдэж буй усны 75 хувийг хэмнэсэн
- Байгаль орчинд сөрөг нөлөөллийг бууруулсан олон төрлийн төсөл хөтөлбөрүүдийн амжилттай хэрэгжүүлэн явж байна
- Байгаль орчин, усны биологийн олон янз байдлыг хянах төсөл малчидтай хамтран хийж байна

Тогтвортой хөгжлийн төслүүд

- 2016 онд нийт 9.7 сая ам.долларыг нийгмийн дэд бүтэц, тогтвортой хөгжлийн төсөл хөтөлбөрүүдэд зарцууллаа.
- "Оюу толгой" ХХК Өмнөговь аймаг, Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдуудтай Хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.

Хамтын ажиллагааны гэрээнд гарын үзэг зурах ёслол (2015 оны 4 дүгээр сар)



Гэрээний хүрээнд “Оюу толгой” ХХК “Хөгжлийг дэмжих сан”-гаар дамжуулан жил бүр 5 сая ам.долларын санхүүжилт хийх бөгөөд дээр дурдсан чиглэлүүдээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд уг хөрөнгийг зарцуулах юм.

Орон нутагт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд

2016 хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд:

- Ханбогдын ус хангамжийн сүлжээний төсөл (6.1 сая ам. доллар)
- Даланзадгад суманд хүүхдийн 2 цэцэрлэг барих төсөл (1.9 сая ам.доллар)
- Даланзадгад суманд спорт, соёлын цогцолбор (388,000 ам.доллар)
- Баян-Овоо суманд Эрүүл мэндийн төв (531,000 ам.доллар)

Одоогоор хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд:

- Ханбогд-Оюу толгой чиглэлийн 35.1 км хатуу хучилттай замын төсөл (23 сая ам.доллар)
- Ханбогдод шинэ сургуулийн барилгын төсөл (2017-2018 онуудад хэрэгжих 3.8 сая ам.долларын төсөл)
- Манлай сумын музейн төсөл (18,200 ам.доллар)
- Сум дундын мал эмнэлэг (529,000 ам.доллар)



Үндэсний ханган нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх нь

- Дотоодын ханган нийлүүлэгчдийн аюулгүй, тогтвортой сүлжээг байгуулах зорилготойгоор үндэсний ханган нийлүүлэлтийн тусгай бодлого баримталдаг;
- Ханган нийлүүлэгчдийн чадавхийг бэхжүүлэхэд онцгой анхаарч, импортыг орлох шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ дотоодод үүсгэн байгуулахад ААН-үүдтэй хамтран ажиллаж байна.
- 2016 оны нийт 990 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласнаас 623 нь үндэсний ААН байсан бөгөөд ил уурхайн үйл ажиллагаанд худалдан авсан бараа, үйлчилгээний 62 хувь нь дотоодод зарцуулжээ.
- Орон нутгийн болон нийт улсын хэмжээнд үйлдвэрлэлийн салбарыг дэмжсэнээр эдийн засгийн хөгжилд хувь оруулж байна.

Ханган нийлүүлэгчдийн форум, 2015 он




Ханган нийлүүлэгчдийн форум, 2017 он



Оюу толгойн гүний уурхайн төсөл

Оюу толгойн орд нь зэс, алт, болон монго агуулсан хэд хэдэн хүдрийн биетээс бүрддэг. Хүдрийн биетүүд нь хойноосоо урагш нийтдээ 12км сунан тогтох бөгөөд үүнд Хюго Дамметтын Хойд Бүс, Хюго Дамметтын Өмнөд Бүс, Оюут хүдрийн биет болон Херуга хүдрийн биет орно. Оюу толгойн ордын нийт баялагийн 80 гаруй хувь нь газрын гүнд оршдог.




Гүнийн уурхайн бүтээн байгуулалт

- Гүнийн уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөө нь хамтын түншлэлд чухал хувь нэмэртэй юм:
 - Гүний уурхайн бүтээн байгуулалтыг явуулахад шаардлагатай тодорхой алхмуудыг зааж өгсөн
 - Бүтээн байгуулалтын санхүүжилт тогтвортой болсон
- Ирэх 4-6 жилд барилгын ажилд шаардлагатай бараа үйлчилгээг дотоодоос худалдан авч, улсын төсөвт төлөх татвар, хураамж нэмэгдэж дотоодын зарцуулалт үлэмж нэмэгдэх юм.



Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөө



- Оюу толгойн II үе шатны санхүүжилтийн \$4.3 тэрбум ам.долларын санхүүжилтийг татсан
- ЕРСМ үйлчилгээг Jacobs Engineering групптэй гэрээлсэн
- Босоо ам 2, босоо ам 5 –ын барилга, уурхайн үйлчилгээ үзүүлэх зэрэг гэрээнүүд зурагдсан
- Гүний уурхайн ажиллах хүч 2,000 гаруй боллоо (90% нь Монголчууд байна)



JACOBS

ХИШИГ АРВИН
УНДСТРАЛ ХХК

REDPATH

MCS

normet



Гүний уурхайн бүтээн байгуулалт тоон хэлээр

Гүний уурхайн анхлан бутлагч 7-давхар өндөр байшинтай тэнцүү.

Хюго Норт Лифт 1 төслийн хүрээнд 200 км хөндлөн малтыг хийж гүйцэтгэнэ. (Хонгилын өндөр нь 5.5м, өргөн нь 5м).

Нийт 6 км урттай 5 босоо амын нэвтрэлтийг цогцлоон, 10 км урттай туузан дамжуулагчийг гүнээс газрын гадаргуу руу суурилуулна.

Бүрэн хүчин чадлаар ажиллах үедээ:

- 50 өрмийн машин
- 25 ачаа зөөгч
- 10 ачаа тээвэрлэгч
- 290 бусад тоног төхөрөмж ашиглагдана

- Олборлолтын арга: Блокчлон олборлох
- Үйлдвэрлэл: жилийн 365 хоног 12 цагийн ээлжээр ажиллана
- Гүний уурхайн дэд бүтэц:
 - 3 засварын цэх
 - 2 өрмийн машины цэх
 - 2 шатахууны цэх
 - 1 тэсэлгээний агуулах
 - 1 царцмал бетоны цэг
 - 10 км урт туузан дамжуулагч



ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭХ

- **Блокчлон олборлох аргаар** гүний уурхайг аюулгүй, оновчтой дизайнаар олборлох
- **Хөдөлмөр хамгааллын технологи** жишээлбэл **Smart Cap** (хүнд даацын болон тээврийн хэрэгсэл жолоодогч нарыг алжаал ядаргаагаас сэргийлэх систем)
- **Виртуал орчын технологийг** ашиглан гүнийн уурхайд ажиллагсдад сургалт явуулах (аюулгүй ажиллагааг мэдэрч таних зорилгоор)
- **Байгаль орчны нөхөн сэргээлт болон биотархалтын** хөтөлбөрүүд
- Монгол Улсын олборлох салбарт **өндөр хэм хэмжээтэй хөдөлмөр хамгааллын соёлыг нэвтрүүлэхэд** анхаарч ажиллана
- **Бидний ажлын арга барилд** тусгагдсан өндөр ёс зүй, сайн компанийн засаглалын хэм хэмжээг үйлдлээрээ жишиглэнэ.



Урт хугацааны түншлэл

Оюу Толгой бол Монгол Улсын Засгийн газар, олон улсын хөрөнгө оруулагч нартай байгуулсан түншлэлийн тод жишээ

- Оролцогч талуудын дэмжлэг – ялангуяа төр засгийн бодлого, зөвшөөрлийн хүрээнд – зөвхөн Оюу толгойн үйлдвэрлэлд төдийгүй томоохон төсөл хөтөлбөрүүдэд чухал ач холбогдолтой
- Итгэлцэл дээр суурилсан урт хугацааны түншлэл бизнесийн үр ашгийг тогтвортой гүйцэтгэх орчныг бүрдүүлж, төсөл хэрэгжиж буй улс орныг нэр хүндийг нэмэгдүүлдэг.



RioTinto



Turquoise Hill
Resources Ltd.

Баярлалаа